



2021 оны 02 сарын 20 нд Оросын өмнөд нутагт шувууны аж ахуйн 7 ажилтан H5N8 вирусээр өвчилсөн 1 тохиолдол бүртгэгдсэн. Бүх хүнд өвчний шинж тэмдэг бага илэрсэн ба хүнээс хүнд дамжсан тохиолдол бүртгэгдээгүй. 2020 оны 10-р сард анх нүүдлийн шувуудад илэрч эхэлсэн ба сарын дараагаас шувууны аж ахуйдад

бүртгэгдэж эхэлсэн. Шувуудын намрын нүүдлийн зам дагуу буюу Европын холбооны улсууд, Иран, БНХАУ, Өмнөд Солонгос, Япон зэрэг улс оронд үргэлжлэн бүртгэгдэж эхэлсэн байна.

Их Британи улсад А хүрээний H5N8 вирусээр үнэг *Vulpes vulpes* болон далайн хав *Phoca vitulina* өвчилсөн 2 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Тухайн өвчлөл бүртгэгдсэн газар нутагт өмнө нь буюу 2020 оны 11-р сард гунгар хун *Cygnus olor* өвчилж байсан. Үхсэн 5 далайн хав, 1 үнэгний эд эрхтэнд шинжилгээ хийж үзэхэд вирусийн өвчлөл илэрсэн ба гунгар хунгаас ялгасан вирустэй ижил төстэй байсан. Далайн хав халдвар авч байсан тохиолдол өмнө нь 2016, 2017 онуудад Польш улсад бүртгэгдэж байсан.

ДОЛОО. 2021 оны 3 дугаар сарын 8-22 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон бусад амьтдын мэдээлэл:

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт болон вирус хэлбэр

№	Мэдээлсэн өдөр	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвшинж	Улс	Муж	Өртсөн нийт зүйлийн тоо	Өртсөн амьтдын зүйл
1	26/2/2021	7/2/2021	H5N8	Афганистан	Херат	22000	Тахиа
2	26/2/2021	17.02.2021	H5N8	Эстони	Ляэне-Вирумаа	78	Тахиа
3	26/2/2021	23/02/2021	H5N8	Швед	Линшөпин	14,300	Тахиа
4	26/2/2021	10/1/2021	H5N8	Орос	Астрахан	7	7 хүн
5	3/3/2021	25/02/2021	H5N1	Нигер	Ниамей хот	28 000	Тахиа
6	10/3/2021	2/3/2021	H5N5	Швед	Треллеборг	18,000	Тахиа
7	15/3/2021	3/8/2021	H5N8	Кувейт	абдали	200	Тахиа
8	15/03/2021	21/11/2020	H5N8	Англи	Сарри	6	Далайн хав <i>Phoca vitulina</i> -5, үнэг-1
9	22/3/2021	2/3/2022	H5N6	БНХАУ	Гуанси	1	50 настай эрэгтэй

Эх сурвалж: Oie.int, Cidrap.umn.edu

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт /зургаар/



ДОЛОО. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2021 оны 3 дугаар сарын 8-22 ны хооронд шувууны томуугийн өвчлөлийн сэжигтэй, үхсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шувууны томуу хариуцсан баг